# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 17 өдөр | Дугаар А/97 | Арвайхээр сум

**Нийгмийн даатгалын сан, эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны орлогын төсвийн хуваарь батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны “2023 оны төсвийн хуваарь батлах тухай” 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумдын нийгмийн даатгалын сан, эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны орлогын сар, улирлын төлөвлөгөөний хуваарийг хавсралтаар батлагсугай.

2.Нийгмийн даатгалын сан, эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, хамрах хүрээг нэмэгдүүлэх, сангийн орлогын төлөвлөгөөг оны эхнээс жигд хангаж биелүүлж, тэтгэвэр тэтгэмжийг хуулийн хугацаанд нь тавьж олгох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж, Нийгмийн даатгалын сан, эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын талаар аймгийн Засаг даргын Тамгын газарт сар бүр танилцуулж байхыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Нийгмийн даатгалын хэлтэс (Н.Норгинбадам)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.ИШДОРЖ

6223 11 0150

D:My Doc. Zahiramj. Zasag darga